0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	120,000.0

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад орлогыг жигд ханган биелүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 25-ны өдрийн 05/38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн эрхэм зорилго нь “Орон нутагтаа бүх шатны Хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн сумын тогтвортой хөгжлийг хангана” гэж тодорхойлсон байна. Мөн 2021 оныг “Хүний хөгжил Эрүүл мэндийг дэмжих” жил болгон зарлаж 9 зорилтын хүрээнд 61 арга хэмжээг төлөвлөж жилийн эцэст дүгнэхэд 92.78 хувьтай хэрэгжсэн байна.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлан нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан журмыг баримтлан сумын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж байна. Сумын дотоод хяналтын ажлын хэсгийг 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/17 дугаар тоот захирамжийн хавсралтаар батлан мөрдөж ажиллаж байна.

Санхүү хяналт аудитын албанаас 2 удаагийн шалгалтаар 2019, 2020 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Нийт 17 зөвлөмж, 1 албан шаардлага, 15.7 сая төгрөгийн акт тавигдсан байна. 5 байгууллагыг бага эрсдэлтэй, 1 байгууллага дунд эрсдэлтэй гэж дүгнэгдсэн. Зөвлөмж, албан шаардлагын дагуу зөрчлийг арилган ажиллаж байна. Төв аймгийн Нийгмийн даатгалын байгууллагаас 2019, 2020 оны санхүүгийн баримтад хяналт шалгалт хийсэн байна. ЕБС, СӨБ, ЗДТГ байгууллагуудад нийт

761.1 мянган төгрөгийн НДШ-ийг нөхөн төлүүлэх акт бичигдсэн. ЭМТ, ИТХ зөрчил илрээгүй байна.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 3,733,991.7 мянган төгрөгөөс 1,0 хувиар буюу 37,339.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 26,137.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцож үзэхэд гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 74,719.0 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 37,379.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн тул материаллаг түвшинг дахин тооцов.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 119,116.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 419,365.6 мянган төгрөг болж, 300,249.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	354,538.6	495,558.9	141,020.4	100.0
<b>Дүн</b>	<b>354,538.6</b>	<b>495,558.9</b>	<b>141,020.4</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 495,558.9 мянган төгрөг байгаа нь төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 385,473.9 мянган төгрөг, арилжааны банкны дансанд 110,085.1 мянган төгрөг байршиж байна.

**Аудитын илрүүлэлт:**

1. ОНХС-н 2021 оны төлөвлөгөөнд гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажилд 15,000.0 мянган төгрөг батлагдсан. Оджи од ХХК-уар 14,896.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлж, Сمارт электрик инженеринг ХХК-уар зураг 800.0 мянган төгрөгөөр хийлгэсэн, нийт зардал 15,696.0 төгрөг болж батлагдсан төсөв 696.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зөрчилд зөвлөмж өгөв.

**3.5.3 Авлага**

Авлага дансны эхний үлдэгдэл 258,283.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 417,619.0 мянган төгрөг болж 159,335.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл**

*/мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төлбөртэй үйлчилгээний авлага		170,498.6	170,498.6
Хувь хүмүүсээс авах авлага	258,283.4	247,072.1	-11,211.3
Байгууллагаас авах авлага		48.4	48.4
<b>Дүн</b>	<b>258,283.4</b>	<b>417,619.0</b>	<b>159,335.6</b>

Эх сурвалж: Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд Сум хөгжүүлэх сангийн 247,072.1 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага 59,2 хувийг, байгууллагаас авах 48.4 мянган төгрөгийн авлага, төлбөртэй үйлчилгээний авлага 170,498.6 мянган төгрөгийн авлага 40,8 хувийг эзэлж байна.

Сум хөгжүүлэх сангийн дараах авлага хугацаа хэтэрсэн байна. Үүнд:

- 25 иргэнтэй холбоотой 209,402.0 мянган төгрөгийн авлага хэвийн байна.
- 37,670.1 мянган төгрөгийн 3 иргэний авлагыг шүүхэд шилжүүлсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

1. Санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг аймгийн ХХААГ-ийн ирүүлсэн авлагын үлдэгдэлтэй тулгахад 833.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зөрчилд зөвлөмж өгсөн.

**3.5.6 Бараа материал**

Бараа материалын эхний үлдэгдэл 239,579.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 216,133.8 мянган төгрөг болж 23,445.4 мянган төгрөгөөр хасагдсан байна.

**Хүснэгт №.3 Бараа материалын үлдэгдэл**

*/мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	171,951.5	143,337.8	-28,613.7
Эм боох материал	24,239.6	32,693.7	8,454.2
Бичиг хэргийн материал	135.2	194.0	58.8
Аж ахуйн материал	676.7	0	-676.7
Түлш шатах тослох материал	742.6	0	-742.6
Барилгын засварын материал	480.0	0	-480.0
Хүнсний материал	801.7	2,589.0	1,787.3
Бусад хангамжийн материал	37,052.0	37,319.3	267.3
Мал амьтад	3,000.0	0	-3,000.0
Сэлбэг хэрэгсэл	500.0	0	-500.0
<b>Дүн</b>	<b>239,579.2</b>	<b>216,133.8</b>	<b>-23,445.4</b>

*Эх сурвалж: Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын үлдэгдэл 23,445.4 мянган төгрөгөөр хасагдсан нь 29,290.4 мянган төгрөгийн тусгай зориулалттай материал болон аж ахуйн материал, 742.6 мянган төгрөгийн түлш шатах тослох материал, 480.0 мянган төгрөгийн барилгын засварын материал, сэлбэг хэрэгсэл, мал амьтадын 3,500.0 мянган төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалжээ.

**Аудитын илрүүлэлт:**

1. Эргэлтийн эмийн сан харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд 165,535.1 мянган төгрөг гүйлгээ е баримтаар баталгаажуулаагүй зөрчилд зөвлөмж өгөв.
2. Засаг даргын Тамгын газар харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд 5,873.4 мянган төгрөг гүйлгээ е баримтаар баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага өгөв.
3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд 6,537.6 мянган төгрөг гүйлгээ е баримтаар баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага өгөв.

**3.5.7 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,649,643.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 9,612,499.0 мянган төгрөг болж, 2,962,855.6 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

*/мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга,байгууламж, орон сууц	4,587,633.8	5,639,211.7	1,051,577.9
Авто-тээврийн хэрэгсэл	390,067.6	386,607.6	-3,460.0
Машин тоног төхөөрөмж	884,855.7	1,103,282.7	218,427.1
Тавилга эд хогшил	193,484.0	245,976.0	52,492.0
Зам, гүүрний байгууламж	415,324.5	2,043,849.1	1,628,524.6
Бусад үндсэн хөрөнгө	17,632.9	15,956.8	-1,676.1
Програм хангамж	5,771.0	5,771.0	0
Биет бус хөрөнгө	154,874.0	171,844.0	16,970.0
<b>Дүн</b>	<b>6,649,643.4</b>	<b>9,612,499.0</b>	<b>2,962,855.6</b>

*Эх сурвалж: Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 187,346.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 2,819,994.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 243,633.1 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

**3.5.8 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 11,152.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 11,291.5 мянган төгрөг болж, 138.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

*/мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	11,152.6	11,291.5	138.9	
Ажиллагчидтай холбогдсон өглөг	2.8	0	-2.8	0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	394.3	317.4	-76.9	2,8
Бусад өглөг	10,755.5	10,974.1	218.5	97,2
<b>Нийт дүн</b>	<b>11,152.6</b>	<b>11,291.5</b>	<b>138.9</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд бараа үйлчилгээний зардлын өглөг 317.4 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 10,846.1 мянган төгрөг, хувь хүмүүст төлөх өглөг 128.0 мянган төгрөг нийт 11,291.5 мянган төгрөгийн өглөг байна.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,583,514.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 8,761,768.6 мянган төгрөг 3,178,254.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үзүүлэлт	/ мянган төгрөг/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,065,544.1	2,065,544.1	0	23,6
Хуримтлагдсан үр дүн	2,283,977.6	5,462,232.0	3,178,254.3	62,3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,233,992.6	1,233,992.6	0	14,1
<b>Дүн</b>	<b>5,583,514.3</b>	<b>8,761,768.6</b>	<b>3,178,254.3</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 8,761,768.6 мянган төгрөг болж 3,178,254.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Үүнд:

Хуримтлагдсан үр дүн 5,462,232.0 мянган төгрөг болж 3,178,254.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн 3,178,254.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Төв аймгийн Эрдэнэсант сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн орон нутгийн төсөв батлах тухай 08 дугаар тогтоолд зааснаар Эрдэнэсант сумын Засаг дарга тайлант онд 169,755.2 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан байна.

Төв аймгийн Эрдэнэсант сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн орон нутгийн төсөв тодотгон батлах тухай 1 дүгээр тогтоолд зааснаар Эрдэнэсант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 169,755.2 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр хэвээр баталж гүйцэтгэлээр 348,258.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 205.2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсөвт төвлөрүүлэх	103,338.1	141,155.6	37,817.5	136,6
Аймгийн төсөвт төвлөрүүлэх	223,483.0	278,722.0	55,239.0	124,7
Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх	169,755.2	348,258.2	178,503.0	205,2
<b>Нийт дүн</b>	<b>496,576.3</b>	<b>768,135.8</b>	<b>271,559.5</b>	<b>154,7</b>

Эх сурвалж: Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Эрдэнэсант сумын орон нутагт төвлөрүүлэх газрын төлбөр, улсын тэмдэгтийн хураамж болон хог хаягдлын хураамж 3,724.6 мянган төгрөгөөр, суутган-2 14,107.5 мянган төгрөгөөр тасарсан нь ковид-19 цар тахлаас шалтгаалан аж ахуй нэгж, иргэдийн борлуулалт буурсан, сургууль, цэцэрлэг ажиллаагүй зэргээс шалтгаалсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төв аймгийн Эрдэнэсант сумын Засаг даргын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,708,340.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 3,708,340.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 266,861.3 мянган төгрөгөөр өссөн нь Эрдэнэсант сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн сумын 2021 оны төсөв батлах тухай 08 дугаар тогтоолд 3,441,478.9 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Эрдэнэсант сумын ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн орон нутгийн төсөв батлах тухай 01 дүгээр тогтоолд зааснаар 153,510.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 3,594,988.9 мянган төгрөгөөр төсвийг тодотгон баталсан байна. Эрдэнэсант сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн орон нутгийн төсөв батлах тухай 9 дүгээр тогтоолд зааснаар Сум хөгжүүлэх сангийн төлөвлөгөөг 102,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 18 хөтөлбөрт зориулан 3,464,169.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,172,943.1 мянган төгрөгийг бараа үйлчилгээний урсгал зардалд, 210,240.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, урсгал шилжүүлгийн зардалд 61,725.4 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2,249,248.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,070,696.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 44,852.4 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 343,542.1 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлого болон урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,208,548.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1,193,255.2 мянган төгрөг, 29,954.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 96,709.6 мянган төгрөгийг нийт 3,528,467.4 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч 96,988.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлж төсвийн тохируулга хийгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,464,169.4 мянган төгрөг буюу 81,0 хувьтай байгаа нь цалин хөлс, НДШ-ийн зардал 2,328,256.6 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 511,264.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 83,919.6 мянган төгрөг, нормативд зардал 97,182.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 15,286.9 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 9,319.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ зардал 7,407.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 58,580.7 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 61,725.4 мянган төгрөгийн зардлууд хэмнэсэн нь шалтгаалсан байна. Үүнд: Сургууль, цэцэрлэг ажиллаагүйгээс үдийн цай хөтөлбөр хэрэгжээгүй, илүү цагийн хөлс олгоогүй, бага сургууль ашиглалтад ажиллаагүйгээс халаалтын зардал хэмнэсэн зэргээс шалтгаалсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 40,700.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээнд 32,661.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 210,240.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Засаг дарга дээд шатны төсвийн захирагчаас 246,812.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, үүнээс хангамж, бараа материалын зардалд 522.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 15,849.0 мянган төгрөг, эд хогшлын зардалд 180.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 28,566.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 137,554.8 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох мөнгөн тэтгэмж 26,002.8 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 26,576.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 1,008.0 мянган төгрөг олгож, нийт 246,692.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 10,432.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 120.0 мянган төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Эрдэнэсант сумын Засаг дарга тайлант онд “Амьюс” ХХК-ийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 70 жил хуримтлагдсан хогийн цэгийг дарж булах, шинээр хогийн цэг үүсгэх, хогийн цэгийн хашаа барих ажилд 55,800.0 мянган төгрөг, 23,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий цэвэр усны усан санд хамгаалалтын хашаа барих, шинэ суурьшлын худгийн барилгын эрчим хүчинд холбох ажил хийгдсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 100,000.0 мянган төгрөгөөр ёслол хүндэтгэлийн өргөөтэй болох, сумын төвийг камержуулахад 20,000.0 мянган төгрөг, ундны усны худаг болон гэрэлтүүлэг нэмэгдүүлэхэд 30,000.0 мянган төгрөгөөр шинэчлэн засварласан байна.

Сумын төвд 3.2км авто замыг ашиглалтад оруулсан байна. 100 хүүхдийн багтаамжтай цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулсан. Аймгийн хөрөнгө оруулалт, иргэдийн хандиваар ногоон байгууламж байгуулсан. Гэр хорооллын айлуудын цэвэр, бохир ус дулааны 176м шугам барьсан зэрэг иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлөөр хангах ажлууд хийгдсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Эрдэнэсант сумын Засаг дарга тайлант онд төсвийн хөрөнгөөр 166,040.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 16,185.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 3,979.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 1,142.2 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө нийт 187,346.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

Төв аймгийн Эрдэнэсант сумын Засаг дарга тайлант онд хандиваар 99,429.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,055,170.1 мянган төгрөгийн барилга байгууламж, 19,900.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 1,628,524.6 мянган төгрөгийн зам гүүрийн байгууламж, 16,970.0 мянган төгрөгийн бусад биет бус үндсэн хөрөнгө нийт 2,819,994.6 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч тайлагнасан байна.

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: 3.2 км автозамыг “Амьюс” ХХК, “Нобле Роуд” ХХК 1,628,524.6 мянган төгрөгөөр, 100 хүүхдийн багтаамжтай Цэцэрлэгийн барилгыг “Төв цогт Өлзийт” ХХК 1,055,170.1 мянган төгрөгөөр, Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар: Бэлчээрийн худаг 2 “Эрдэнэдрийлинг” ХХК 23,900.0 мянган төгрөгөөр, 176м дулаан, цэвэр бохир усны шугамыг “Мөнхчандмань Илч” ХХК 72,600.0 мянган төгрөгөөр, Сумын 2020 оны

төсвийн шилжих үлдэгдлээр Хуучин цэгийг дарж булах ажил “Амьюс” ХХК 55,800.0 мянган төгрөгөөр, ОНХС-ийн хөрөнгөөр Гудамж талбайг камержуулах ажил “Хавт хүч” ХХК 20,000.0 мянган төгрөгөөр, Гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажил “Оджи Од” ХХК 15,000.0 сая төгрөгөөр, Ундны усны худгийн “Алтан сэвсүүл” ХХК 10,000.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс хугацаандаа оруулсан 150 мэдээлэл, хугацаа болоогүй 4, мэдээлээгүй 1 мэдээлэл байна. Тус байгууллага 5,0 саяас дээших орлогын 22, зарлагын 24 гүйлгээ байршуулж, 5,0 саяас дээших худалдан авалтын 24 гүйлгээ байршуулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.9.3 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг эх үүсвэрээс 359.5 мянган төгрөгөөр илүү баталсан зөрчилд 1 зөвлөмж өгсөн байна.

2020 онд Сум хөгжүүлэх сангийн 17,187.3 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах 1 албан шаардлага өгсөн байна. Тухайн зээлийг авсан 2 иргэнийг Шүүхэд шилжүүлсэн 2021 онд өрийн барагдуулалт хийгдээгүй гэсэн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тус байгууллагад балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд байхгүй байна.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 37,647.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

##### 4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эрдэнэсант сумын Засаг дарга улсад төвлөрүүлэх 2 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 16,679.0 мянган төгрөгөөр, аймагт төвлөрүүлэх 3 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 3,135.9 мянган төгрөгөөр, орон нутагт төвлөрүүлэх 4 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 17,832.1 мянган төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "тохиолдсон байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Улс, аймаг, орон нутагт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь жингд ханган биелүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>											
1	Засаг дарга	1	37,647.0							1	37,647.0
2	Ерөнхий боловсролы сургууль	6	51,561.8	2	6,478.1	1	310.1			3	44,773.6
3	Хүүхдийн цэцэрлэг	3	713.0	1	-					2	713.0
4	Соёлын төв	-	-								
5	Эргэлтийн эмийн сан	3	165,535.1							3	165,535.1
6	Эрүүл мэндийн төв	6	80,976.3			1	2,242.9	1	-	4	78,733.4
7	Орон нутгийн хөгжлийн сан	1	696.0							1	696.0
8	Сум хөгжүүлэх сан	1	833.9							1	833.9
9	Засаг даргын Тамгын газар	7	76,244.2	1	33,427.4	1	200.0	2	14,989.4	3	27,627.4
10	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	2	6,537.6					1	6,537.6	1	-
11	Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан	-	-								
<b>Дүн</b>		<b>26</b>	<b>380,839.4</b>			<b>3</b>	<b>2,753.0</b>	<b>4</b>	<b>21,527.0</b>	<b>19</b>	<b>356,559.4</b>

